

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар A/18

Даланзадгад сум

┌ Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг шинээр олгох, хугацааг
сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, 19.18 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосон, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаар шийдвэрлэсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон, сунгасан байгууллагуудын тусламж үйлчилгээнд мэргэжил арга зүй удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс (Б.Батболд), Удирдлага, төлөвлөлт санхүүгийн хэлтэс (Б.Ганшагай), Хяналт шалгалтын хэлтэс (Б.Оюунсүрэн), тусгай зөвшөөрлийн комиссын гишүүн, Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм эмнэлгийн хэрэгслийн улсын ахлах байцаагч (У.Дөшбат) нарт тус тус даалгасугай.

3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг холбогдох стандарт дүрэм журмын хүрээнд үзүүлж, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Б.Цагаанцэнд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

• 462501135

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн
А/18 дугаар тушаалын хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг шинээр олгосон, тусгай зөвшөөрлийн
хугацааг сунгасан эрүүл мэндийн байгууллага

Д/д	Байгууллагын нэр, тусгай зөвшөөрлийн дугаар	Аж ахуй нэгжийн ТТД	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрли йн хүчинтэй хугацаа	Хаяг байршил
Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан					
1	Говь хан сайхан ХХК ЭХ -19/14/99	3626598	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ /дотрын өвчний үзлэг/	2030 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хүртэл	Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 6-р баг 112-р байр 102 тоот
Тусгай зөвшөөрлийг шинээр олгосон					
1	Тор гүн ХХК	3663957	Ахуйн шавж мэрэгч устгал, ариутгал халдваргүйтгэх үйлчилгээ эрхлэх	2028 оны 04 дүгээр сарын 09- ний өдөр хүртэл	Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 7-р баг, Оюут 8-17 тоот

oOo